

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”**

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234722

**МӨРДЭНДЭВИЙН ЯДАМСҮРЭНГИЙН “ГУРВАН ХҮҮХЭН”
ТУУЖИЙН ХАМ СЭДВИЙГ ЗАДЛАН ШИНЖЛЭХ НЬ:
ЭМЭГТЭЙЧҮҮД БА ХҮЧ**

Г.Нандинбилиг
И.Даваадорж

Товчлол: Энэхүү өгүүлэлд бид Монголын орчин үеийн уран зохиолын үндэс суурийг тавилцсан нөлөө бүхий зохиолч Мөрдөндэвийн Ядамсүрэнгийн “Гурван хүүхэн” туужийн хам сэдвийг задлан шинжилж, далд утгыг тайлан тайлбарлалаа. Аливаа зохиолыг гүнзгий ойлгохын тулд бичвэрийн дотоодод орших түүх, нийгмийн үзэгдэл, давхраажилт, улс төрийн үзэл суртал, шашны итгэл үнэмшил, соёл бэлгэдэл зэрэг хам сэдвийг цогцоор харж, зохиолын бүтвэр хэсэгтэй холбон тайлбарлах нь зохиолчийн илэрхийлэхийг хүссэн далд санааг илчлэн гаргахад чухал үүрэгтэй. Тус туужийн далд утгыг тайлан тайлбарлахын тулд утга зохиол, нийгэм, улс төр, соёл, эмэгтэйчүүд, зохиолч болон эдийн засгийн хам сэдвийг шинжилж, зохиол болон зохиолыг уншихуй (reading practice)-д гүйцэтгэж буй үүргийг авч үзэв.

1936 онд анх хэвлэгдсэн “Гурван хүүхэн” нэртэй тус туужийн үйл явдал нь эмэгтэй дүрийн “гэрээс гарах” өгүүлэмжээр асуудал дэвшүүлэн сэдэлжих бөгөөд хувьсгалын эхэн үеийн монголчуудын аж төрөл, хуучин ба шинэ нийгмийн суртлыг харшуулан үзүүлэхдээ эмэгтэй биеийг объект болгож, хуучин нийгмийн мөхөл сүйрэл зайлшгүй болохыг хүрээний хөнгөн самуун амьдралд хөл алдаж, яр шархандаа баригдан, хөсөр үхэж буй Занданбалын дүрээр, шинэ нийгмийн ололт, эрдэм боловсролыг багш Хоролмаагийн дүрээр, нийгмийн шилжилтийн үеийн алдаа оноог Хас-Эрдэнийн дүрээр, төлөөлүүлэн харуулсан байна. Туужийн эмэгтэйчүүдийн бие даан шийдвэр гаргах, сурч боловсрох үйл хэрэгт шинэ, хуучин нийгмийн төлөөлөл хэрхэн эерэг сөргөөр оролцон нөлөөлж буйг харуулахдаа нийгэм, соёл, улс төр, эдийн засгийн хам сэдвээр дамжуулан илэрхийлсэн нь онцлог байна.

Түлхүүр үг: Уран зохиол, хам сэдэв, гэрээс гарах чиг үүрэг, нийгэм, соёл, улс төр, эмэгтэйчүүд, хүч

Зохиолч М.Ядамсүрэнгийн намтар уран бүтээлийг үе үеийн утга зохиол судлаач эрдэмтэд судалж ирсэн бөгөөд *Монголын орчин үеийн уран зохиолын түүх I* (1921-1940) ботид “Гурван хүүхэн” туужийг шинжлэн, гурван хүүхний дүр нь “...тус бүртээ тодорхой үзэл санаа, нийгмийн хандлагыг төлөөлөн дүрслэгдсэн буюу зохиолын гол дүрүүдэд хувьсгалын эхэн үеийн түүхэн тодорхой хүмүүсийн нийтлэг шинжийг ерөнхийлөн зангидаж багтаан, төвлөрүүлж хамгийн түгээмэл гол шинжээр нь үзүүлсэн байна” (1985: 351) хэмээн дүгнэжээ.

Мөн БНХАУ-ын эрдэмтэн Ван Мандуга “Залуу хос”, “Гурван хүүхэн” туужид зохиолчийн авьяас тодорхой илэрсэн хэмээн үнэлж, “Гурван хүүхэн” туужид нийгмийн амьдралын хуучин шинийн зөрчил дунд хувьсгалт үзэл санаа нэвтэрч хүмүүс хоцрогдсон хуучин амьдралын хүрээнээс шинэ байдал руу шилжсэн төвөгтэй явцыг өгүүлэхдээ, нэг нутгийн гурван хүүхний өөр хувь заяагаар төлөөлүүлэн харуулжээ” (2015: 46) хэмээн дүгнэсэн байна.

Зохиолын хам сэдэв нь дүрийг тодорхойлж буй тухайн цаг үеийн нийгэм-соёлын нөлөө, үйл явдал, үзэл бодол зэрэг зохиолын хамгийн их мэдээлэлтэй хэсэг юм (Нандинбилиг, 2018:17). Өмнө дурдсан жишээнээс харахад “Гурван хүүхэн” туужийн дүр аль нийгмийг төлөөлж буй, нэгэн нийгэм, эдийн засгийн тогтолцооноос нөгөөд шилжиж үйл явц зохиолд хэрхэн илэрснийг шинжилсэн зүйл зонхилох боловч хам сэдвийг тухайлан үзсэн зүйл ховор байна. Уран зохиолын аливаа бүтээлийн хам сэдвийг анхааран үзэх нь тухайн зохиол бүтээлийг ойлгож хүлээж авах, тусган эргэцүүлэх байдлыг нэмэгдүүлдэг. Хам сэдэвт төвлөрсөн уншлага нь тухайн бичвэрийн дотоодод орших ертөнцийн репрезентаци¹ хэн, нийгмийн аль бүлгийн хүсэл, ашиг сонирхолд үйлчилж буйг онцлон авч үздэг. Анх XX зууны эхэн үед өрнө дахинаа төлөвшсөн уг шинжлэл нь анги, нийгмийн давхраажилтад тулгуурласан тэгш бус байдлыг Марксист онолын үүднээс шинжлэн үзэж, улмаар феминизм зэрэг онолоор баяжсан байна (QCAA, 2017: 13-14). Тиймээс бид энэ удаа М.Ядамсүрэнгийн “Гурван хүүхэн” туужийг хам сэдвийн үүднээс шинжилж, утга зохиол, нийгэм, улс төр, соёл, эмэгтэйчүүд, зохиолч болон эдийн засгийн хам сэдвийн хүрээнд далд утгыг тайлан тайлбарлах юм.

I. Утга зохиолын хам сэдэв

Алив нэг уран зохиолын бүтээл нь дотооддоо тухайн улс, үндэстэн болон дэлхийн уран зохиолын нөлөө тусгалыг ухамсартай болон ухамсаргүйгээр өвлөн тусгаж, хадгалж байдаг. Утга зохиолын хам сэдэв нь тухайн бичвэр дэх аман болон бичгийн уран зохиолын нөлөө, тусгалыг тодруулахад чиглэх ба уг ойлголт нь цааш улам гүнзгийрч, интертекст хэмээх ойлголттой холбогддог. Утга зохиолын хам сэдвийн нэгэн томоохон жишээ бол Хомерын “Одиссей” хөлгөн тууль болон Ж.Жойсын “Үлисс” романы дүр, өгүүлэгдэхүүн түүнийг зуучлан илэрхийлэх бэлгэдлийн холбоо хамаарал юм. Ж.Жойсын “Үлисс” гэх романы нэр нь латин хэлний Одиссей гэх үгээс үүдэлтэй. Зохиолч гол дүр Леополд Блүүмийг Одиссейгоор төлөөлүүлж, романы 18 хэсгийг Одиссей Трой хотоос Итак аралдаа хүрэх аялалтай дүйлгэн авч үзэх сэжим, хэв дардас (*pattern*)-ыг үлдээсэн байдаг. “Жойс зохиолоо Хомерын загвараар бичиж, хэд хэдэн бэлгэ тэмдэг гэмээр төсөөтэй, уялдаатай үйл явдлыг дүрслэн үзүүлснээрээ Блүүм хэдий энгийн, сайн иргэн хүн ч гэлээ баатрын шинж чанар агуулж байж болох

¹ Семантик үнэлгээ өгч болох аливаа зүйлд репрезентаци (*representation*) гэх нэр томъёог ашигладаг. Дүр, загвар, хэл, шинжлэх ухаан, урлагийн символик системүүд нь репрезентацийн гадаад хэрэгсэл болно. “Танин мэдэхүй бол урьдчилсан зохиосон схем хэрэглэж судалж буй үзэгдлээ загварчлах үйл явц” (Баттөмөр, 2005: 15) бөгөөд судалж буй зүйлтэй төстэй загвар зохиох нь танин мэдэхүйн зорилт мөн.

юм гэсэн санааг давхар дэвшүүлдэг” (Утга зохиол, 2016: 221)². Үүнээс ургуулан М.Ядамсүрэнгийн “Гурван хүүхэн” туужийн үйл явдлыг монгол үлгэрийн “гэрээс гарах” чиг үүрэгтэй холбон үзэж болно.

Зохиолын үйл явдал эхлэх шалтгаан нь гол дүр Хас-Эрдэнэ гэрээс гарч, хот хүрээ орж, шинэ цагийн сургуульд суралцах буюу өөрийн ажил амьдралын замыг хайж байна. Ардын үлгэрт гэрээс гарч байгаа баатрууд ямагт эрэгтэй дүр байдаг бол харин М.Ядамсүрэнгийн “Гурван хүүхэн” туужид гэрээс гарч буй дүр нь гэрлэх насны эмэгтэйн дүр байгаа юм. Уламжлалт нийгэмд эмэгтэй хүний гэрээс гарах тухай ойлголт бол зөвхөн эр нөхөрт очих буюу гэрлэх ёслолтой л холбогдож байдаг. Харин “Гурван хүүхэн” туужид нас биед хүрч буй эмэгтэй эрдэм сурахаар эцгийн гэрээс мордож байна. Үүнээс үзэхэд М.Ядамсүрэн “Гурван хүүхэн” тууждаа ардын үлгэрийн гэрээс гарах чиг үүргийг эрэгтэй биш, эмэгтэй дүр дээр тавьж үзүүлснээр зогсохгүй эмэгтэйчүүдийн гэрээс гарах чиг үүргийг зөвхөн гэрлэлт биш, эрдэм сурах үйл хэрэг болгож үзүүлснээрээ шинэлэг бөгөөд дэвшилтэт чанартай байна.

Дүр, баатар ямар нэг зүйлээр дутагдаж, тухайн зүйлээ олж авахаар гэрээс гарах нь монгол үлгэрийн хэв шинж юм. В.Пропп “Үлгэрийн морфологи” (1928) бүтээлдээ шидэт үлгэрийн 31 чиг үүрэг (функц³) -ийг тогтоож, алив үлгэрийн формаль байгууламж, үйл явдлыг тэдгээр чиг үүргийн хүрээнд шинжлэн үзэх боломжтой хэмээжээ. Бидний судлан буй туужтай холбогдох гэрээс гарах функц нь *гэр бүлийн нэг гишүүн гэртээ байхгүй байх* гэсэн утгыг илэрхийлэх бөгөөд β үсгээр тэмдэглэж, *эзгүй байх* хэмээн товчилдог. Гэрээс гарах буюу “... эзгүй байх функцийн түгээмэл хэлбэр нь ажил үйл бүтээхээр явах, ой руу явах, арилжаа худалдаа хийхээр явах, дайнд явах” (Пропп, 2009: 26) зэрэг юм. “Гурван хүүхэн” туужид Хас-Эрдэнийн гэрээс гарах анхны шалтгаан нь Хоролмааг анх хараад түүн шиг гоё хүүхэн болох сон гэх хүсэл байв. Уг санаа зохиолд “... Хас-Эрдэнэ анх гагцхүү Хоролмаа шиг хотын цэвэрхэн дэгжин хүүхэн болох юм сан хэмээж санадаг байсан” (МӨТД, 2015: 221) гэж өнгөц шохоорхлоор илэрч байгаа шиг боловч нарийн шинжилбэл түүний дутагдаж буй зүйл нь “насанд хүрсэн эмэгтэй хүн болох”-ыг хүсэж байгаа далд утга байж болох юм. Хас-Эрдэнэ анх Хоролмаагийн гадаад харагдах байдлыг үзээд, түүний адил болохыг хүсэж байсан ч зохиолын өрнөлд Хоролмаа шиг эрдэм боловсролтой болохыг хүсдэг. Эл санааг зохиолд “...Хоролмаагаас элдэв зүйлийг сонирхон сонссоор бодлого нь нэлээд өргөжиж, бичиг үсэг сурах элдэв юм үзэх, Хоролмаа шиг настай томоотой улс хүндлэгдэх юм сан гэж санадаг болсон...” (МӨТД, 2015: 221) хэмээн илэрхийлжээ. Гэрээс гарах функцийг идэвхжүүлэх дүрийн дотоод сэдэл нь анхлан элдэв зүйл ганган хотын бүсгүй болох байсан бол, улмаар эрдэм боловсрол эзэмшиж, нийгэмд эзлэх байр суурь, статусаа дээшлүүлэхийг хүсэл

² Ж.Жойс Хомерын “Одиссей” туулийн дүр, өгүүлэмж зэрэг элементийг хэрхэн орчин үежүүлэн ашигласан талаар Don Griff (1988). *Notes for Joyce: An Annotation of James Joyce's "Ulysess"*. California: University of California Press бүтээлтээс үзнэ үү.

³ Шидэт үлгэрийн дүр өөрчлөгдөх боловч үйл явдал, функц өөрчлөгдөхгүй. “Тиймээс дүрийн функц бол үндсэн бүрэлдэхүүн бөгөөд түүнийг юун түрүүн ялган авах хэрэгтэй... Үлгэрийн тогтвортой, байнгын элемент болох функцийг тодорхойлохдоо (i) түүний мөн чанарын талаарх товч дүгнэлт, (ii) нэг үгээр илэрхийлсэн хураангуй тодорхойлолт, (iii) нөхцөлт тэмдэглэгээг өгнө” (Нямсүрэн, 2017: 21).

болж хувирч байна. Зохиолчийн хүүрнэлээр дамжин илэрсэн дүрийн уг дотоод өчил нь гэрээс гарах функцийг угтан илэрч, сэдэлжүүлэх үүрэгтэй юм. Үүнийг Проппын 31 функцэд “а - гэр бүлийн нэгэн гишүүн алив зүйлээр дутагдах эсвэл ямар нэгэн зүйлтэй болохыг хүсэх” (Propp, 2009: 35) хэмээн нэрлэн тэмдэглэдэг. Энэхүү чиг үүрэг нь “Гурван хүүхэн” туужийн гол дүр Хас-Эрдэнийг хот газар очиж, эрдэм боловсрол эзэмших, нийгэмд эзлэх байр сууриа дээшлүүлэх хүслээр илэрч байна.

Аливаа шидэт үлгэр, баатарлаг туульсад туслагч баатар (донор)-ын үйлдэл чухал үүрэгтэй. Жишээлбэл, “Өнчин Бушхүү” үлгэрт тариачны нутгийн өнчин Бушхүү түс годилын үлгэрт гол баатрын гэрээс гарах функц (β^3)-ийг эхнэртэй болох буюу α^1 – сүйт хүн, хүн дутагдах функц сэдэлжүүлж, хааны охиныг бэр буулгахыг хүсдэг. Хаан өнчин Бушхүүгийн нэг нүд, өрөөсөн гар, хөлийг огтчин хаях (α^6 – биед гэмтэл учруулах) -д, Бушхүү үхэлтэй шатартаж бүхүй үед Цагаан өвгөний тусалж, шидэт үгийг заадаг (D – Донорын анхны үйлдэл, F^1 – шидэт зүйлийг өгөх). Ийн Бушхүү алив саад бэрхшээлийг давж, хааны гүнжтэй гэрлэдэг (H – хорон санааттай баатар тэмцэлдэх, W^* - хурим). Эл үлгэрийн өгүүлэгдэхүүнийг товчилсон функцээс ажвал Бүшхүүд шидэт үгсийг соёрхон заах туслагч баатар (донор) чухал ач холбогдолтой байна. Үүний нэгэн адил М.Ядамсүрэнгийн “Гурван хүүхэн” туужийн дүр Хоролмаа бол Хас-Эрдэнэд туслах, гэрээс гаргах буюу эцэг эхийн нөлөөнөөс холдож, зорьсон үйл хэргээ гүйцэлдүүлэхэд чухал үүрэгтэй, донорын хэв шинжтэй дүр байна. Дараах хэсгээс эл санааг харах боломжтой.

... Хоролмаа ирээд хоёр сар шахам болж, нэгэнт буцахад ойртсонд Хас-Эрдэнэ ямагт бачимдан Хоролмааг үргэлж шаардаж гуйн хамт явахыг эцэгтээ хэлүүлэхийг оролдох болов. Нэгэн өдөр Хоролмаа Хас-Эрдэнийн эцэг эхэд сургуульд явуулбал сайн болохыг хэлсэнд... харин эцэг эх хоёр нь төдий л дургүй бус байдалтайгаар эцэг нь энэ муу юм сурах болов уу даа, уг нь юм сурвал сайхан юм байна хэмээсэнд... Хоролмаа улам шавдан шаардаж, зүгээр зүгээр ер санаа зовох юмгүй, тэнд сургуулийн газар гэрээс жаргалтай тун сайхан шүү. Хүүхэн чинь удахгүй их эрдэм сураад ирнэ. Би тэнд хамт байх тул элдэвт тусалж харж үзэж байна (МӨТД, 2016: 221).

Зохиолын энэхүү хэсэгт Хас-Эрдэнийн эцэгтээ зориглон эс өгүүлж чадах эрдэм сурах, хот газар очих хүслийг Хоролмаа хэлж байна. Хоролмааг үлгэрийн туслагч баатартай харьцуулан үзвэл үйлийг бүтээх шидэт эдлэл хэрэгсэл, үг шившлэгийг бэлэглэн соёрхохгүй боловч гэрээс гарах хүслийг гүйцэлдүүлэхэд чухал үүрэгтэй байна. Эндээс бид Хас-Эрдэнийн дүрийг дутагдаж буй алив зүйлийг олж авахаар гэрээс гарах үлгэрийн гол баатартай адилтгаж, Хоролмааг элдэв үйлийг бүтээхэд туслах чиг үүрэг бүхий туслагч баатартай хоймсуулан үзэж болох юм.

Харин туужийн өрнөл хэсэгт гол дүрд идэвхийлэн нөлөөлөх Занданбалын дүрийг үлгэрийн баатарт саад тотгор үүсгэх хорон санаат баатартай ижилсүүлж болно. Зохиолын үйл явдлыг “...дагавар охин хойд эхдээ ад үзэгдэж, хөөгдөөд ямар нэгэн сорилттой тулгардаг бөгөөд сорилтыг амжилттай давсны төлөө шан

урамшуулал хүртдэг бол энэ сорилтыг давж гараагүй хойд эхийн охин шийтгэл хүлээж байдаг” (Нандинбилиг, Дулам, 2020: 145) дэлхий дэхинд түгээмэл хойд эх, дагавар охины тухай мөчлөг үлгэртэй холбон үзье. Хойд эх, дагавар охины мөчлөг үлгэрт “сорилт-шагнал-шийтгэл” гэсэн гурвал тогтмол оршдог. Хот газар ирэн, сургуульд суралцаж буй Хас-Эрдэнэ хичээлийн чөлөөгөөр хоршоо орох гэж яваад нутгийн хүүхэн Занданбалтай санамсаргүй таарч, хотын баруун хойд өнцөг дэх таван гудамжнаа байх гэрт нь очдог. Ийн Занданбал Хас-Эрдэнийг нэгэн нутгийн нөхөр хэмээн хүрээний хятад худалдаачидтай нийлэн цайлах ч түүнээс хэтийдэн биеэ үнэлэх үйлдэлд татан оруулдаг. Уг сорилтыг зохиолд доорх байдлаар дүрслэн өгүүлсэн байна.

...Занданбал байн байн архиар шахаж, хэдий ууж чадахгүйг хэлэвч хэрэгсэхгүй цутган уулгана... Хас-Эрдэнийн нүд эрээлжилж толгой нь манаран ухаан мэдрэл дутуу мэт болсонд... нэг орны дээр хэвтүүлж битүү цагаан хөшигийг буулгав. Хас-Эрдэнэ хэвтэх сацуу архиндаа цохигдон мэдрэлгүй унтав. Тэндээс Занданбал Хас-Эрдэнийн согтсоныг бодохгүй тэдгээр иргэд лүгээ үнэ хэлэлцэн битүү цагаан хөшигний дотор ээлжээр оруулна (МӨТД, 2015: 228).

Уг хэсэгт өгүүлэх Занданбалын үйлдэл нь илт өнгөндөө найрсаг харилцаа мэт боловч үнэн хэрэгтээ Хас-Эрдэнийг эрдэм боловсролын замаас гажуудуулж, “... хашир тогтворыг олоогүй залуу хөнгөн сэтгэл нь завсрын эдгээр үзэгдэл байдалд автагдан” (Мөн тэнд: 229) сарних “сорилт”-ын үндэс болж байна.

Туужийн өгүүлэгдэхүүний удаах хэсэгт Хас-Эрдэнэ Занданбалын өдүүлсэн үйлдэлд гаршин дадахад туслагч баатар (донор)-ын шинжтэй Хоролмаа уг үйлдлийн үр дагаврыг сануулна. Гэсэн ч гол дүр Хас-Эрдэнэ Хоролмаагийн үгийг үл хэрэгсэж, эцэстээ тухайн үйлдлийн хор уршгийг ойлгон нөхцөл байдлаас гарах шийдвэрийг өөрөө эрэлхийлдэг. Эдгээрийг хойд эх, дагавар охины мөчлөг үлгэрт тогтмол байх “сорилт-шагнал-шийтгэл” гэх гурвалтай харгуулан үзвэл анхлан Хас-Эрдэнэ Занданбалын үйлдэл, үгэнд автан орж, хүрээний хятадуудад биеэ үнэлэх “сорилт”-той тулгардаг. Үүний удаагаар Хас-Эрдэнэ туслагч баатар (донор)-ын үүрэгтэй Хоролмаагийн тусламжтайгаар сорилтыг даван гарч чаддаг. Ийн үзвэл тухайн гол дүр хэсэг хугацаанд өөрийн зорилгыг мартсан ч сорилтыг авсны шагналд Хас-Эрдэнэ бага сургуульд бичээчийн ажилтай болж, Мандах хэмээх багш нөхөртэй болсныг зохиолын төгсгөлд өгүүлдэг. Харин тухайн сорилтоос үүдэх шийтгэл нь дүр өөрийн үйлдсэн өмнөх үйлдлийг шинжлэн, үл таашаах, жигших сэтгэл зүйн байдлаар илэрч байна.

II. Нийгэм, улс төрийн хам сэдэв

Нийгмийн хам сэдэв нь тухайн зохиол энгийн болоод нийлмэл нийгмийн алинд өрнөж буй, тухайн нийгмийн давхраажилт нь дүр хийгээд баатарт хөдөлшгүй тогтсон статусыг олгох эсвэл өөрийн үйлдэхүй болон эс үйлдэхүйгээр дамжуулан өөрчлөх боломжтой байр суурийг санал болгож байна уу гэдэг асуудал дээр голчлон төвлөрдөг. Цаашилбал улс төрийн хам сэдэв нь тухайн нийгэм цаг үеийн үзэл суртал, ухуулга болон зонхилох засаглалын хэлбэрт ач холбогдол өгөх зохиолчийн хүүрнэлээр дамжин илэрдэг. М.Ядамсүрэнгийн тус туужийн нийгэм,

улс төрийн хам сэдвийг шинжлэн үзэхэд ялгаатай ашиг сонирхол бүхий бүлгийн эмэгтэйчүүдийн шийдвэрт хандах байдал, хуучин ба шинэ нийгмийн төлөөллийг хүлээн авах хандлага, дүрийн хэлээр дамжуулан нийгмийн зүгээс эмэгтэйчүүдэд ашиглаж буй ятгалгын аргыг шинжлэх боломжтой байна.

“Гурван хүүхэн” туужид ялгаатай ашиг сонирхол бүхий нийгмийн бүлгийн эмэгтэйчүүдийн шийдвэрт хандах байдлыг дүрслэн үзүүлэхдээ хуучин болон шинэ нийгмийг харшуулан илэрхийлжээ. Энэхүү санааг Хас-Эрдэнэ гэрээс гарч, хотод газар ном эрдэм сурахыг дэмжих болон эс дэмжих баатрын үгээр дамжуулан тодотгосон байна. “Феодалын хор, гишүүний тусыг гэр бүлээр танив” хэмээх туужийн гутгаар хэсэгт Хас-Эрдэнэ эцгийн хамт Санж мээрэнгийн жасаанд очиход, Хас-Эрдэнийн хот газар очиж, сургуульд сурах шийдвэрийг хэлэлцдэг.

Хуучин нийгмийн төлөөлөл	Шинэ нийгмийн төлөөлөл
... Хас-Эрдэнийг явуулах хэмээн шийдвэрлэснээ хэлсэнд тэдний жасааг уншсан Дамдин гэлэн, мээрэн Санж хоёр зэргээр хориглож энэ Дугар одоо завхарсан юм хийж байх юм. Хоролмааг үзээд л амархан юм санаж байна уу. Энэ нялх бага хүүхэн танихгүй газар мэдэхгүй олон аавын хүүхэд цугларсан газар нэг шалдар булдар бүсгүйг дагаж очоод өвдөөс яах юм. Олон хүүхэдтэй дарвин хөөрөөд орос газар явчихваас яах юм. Ус үзээгүй гутал тайлж, уул үзээгүй хормой шуух гэж Дугар одоо нялх томоогүй хүүхнээсээ салах нь байна... (МӨТД, 2015: 222).	-Явуулах нь зөв байлгүй яах вэ, яваад эрдэм сураад ирвэл наанадаж танд тустай, цаанадаж улсдаа хэрэгтэй шүү дээ. Ер нь хүүхдийг багаас нь явуулж элдэв юм үзүүлэх хэрэгтэй. Та мөнх дагаж явах биш, хэрэв одоо эрдэм сурвал хэт нь таныг үхсэн хойно амар амьдарна шүү дээ... Та нар ямагт юмыг урьдын байдлаар бодох юм. Эрдэм сургуулийг оролдвол бүстэй бүсгүй ямар ялгаа байх вэ? Урьд феодалын үед бүсгүйчүүдийг гэрийн боол, эрийн зарц болгож байсны харгаагаар одоо хүртэл бүсгүйчүүд хоцрогдож яваа хэрэг, одоо ардын засаг мандсанаас нааш энэхэн арван хэдэн жилд хэчнээн олон эмэгтэйчүүд эрдэм сургууль сураад байна (Мөн тэнд).

Хүснэгт 1. Гэрээс гарах шийдвэрт нийгмийн бүлгийн гишүүдийн үзүүлэх хариу үйлдэл

Дээрх хүснэгтээс харахад эмэгтэйчүүдийг боловсрол эзэмшихэд тухайн нэг нийгмийн бүлэг хэрхэн хандаж буйг хуучин ба шинэ нийгмийг төлөөлөх дүрүүдийн хэл яриагаар тодорхой харуулсан байна. 1924 оны Үндсэн хуулийн XI зүйлд “Тус улсын харьяат ард түмэнд угсаа, шашин, эрэгтэй, эмэгтэй гэдэг ялгаваргүй нэгэн адил эрхийг эдлүүлбэл зохино” (1924 оны Монгол Улсын Үндсэн хууль) хэмээн зааснаар эмэгтэйчүүд суралцах, ажиллах, алив нэгэн нийгмийн үйлд оролцох эрхтэй болсон ч зохиолын гол дүр эцгийн хараат, алив нэгэн шийдвэрийг гаргахад Хас-Эрдэнийн эцэг Дугарт нөлөөлөх эрэгтэйчүүд голлосон нийгмийн бүлгийн үзэл бодол илүү жинтэй байгааг харж болно.

Хуучин нийгмийн төлөөлөл дүрүүдэд жасааг уншсан Дамдин гэлэн, мээрэн Санж хоёрыг нэрлэж болох бөгөөд тэд Хас-Эрдэнийг гэрээс гарахад тохиолдох эрсдэлийг өгүүлэх байдлаар хорьж буй нь хэдий сэрэмжилж буй үйлдэл мэт боловч эмэгтэйчүүдийг гэр, аж ахуйн хүрээнд хаших уламжлалт эцгийн эрхт ёсыг төлөөлсөн далд санааг илтгэж байна. Нөгөө талаас сумын нарийн бичгийн

дарга, эвлэлийн гишүүн Цэрэн эрдэм боловсрол эзэмших нь ирээдүйд бие даан амьдрахад чухал нөлөөтэй болохыг сануулан хэлж, эцгийн шийдвэрт нөлөөлж байгаа нь шинэ нийгмийн төлөөлөл, эмэгтэйчүүдийг гэр ахуйн хүрээнээс татан гаргаж, нийгмийн хүрээнд оруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Бусдад нөлөөлөх шинжтэй баатрын дуу хоолойгоор эмэгтэйчүүдийн бие даан суралцах, ажиллах шийдвэрт шинэ, хуучин нийгмийн тодорхой бүлгийн үзүүлж буй хариу үйлдэл, хандлагыг харуулсан бол зохиолын удаах хэсэгт уг нийгмийн бүлэгт хандаж буй байдлыг зохиолч дүрийн болон өөрийн хүүрнэлээр өгүүлсэн байна.

Дамдин гэлэн, Санж мээрэн Хуучин нийгмийн төлөөлөл	Сумын нарийн бичгийн дарга, эвлэлийн гишүүн Цэрэн Шинэ нийгмийн төлөөлөл
“... аргатай феодалуудын сурталд автагдаж, урьд санаснаа ухран байхыг хажуугаас Хас-Эрдэнэ бүрнээ сонсож зүрхэнд хутга шаасан мэт бухимдан тэссэнгүй хоёр нүдний нь нулимс бүрхэж лам хар хоёр феодалыг дотроо харааж хэрэггүй энэ солиг шиг феодалын жасаанд ирлээ” хэмээжээ. (МӨТД, 2015: 222).	“... хажуугаас тэндэх сумын нарийн бичгийн дарга, эвлэлийн гишүүн Цэрэн олонд хүндтэй ард нийт лүгээ ихээхэн холбоотой сайн ажилчин бөгөөд түүний үгийг олноор их л хэрэгсдэг болой...” (Мөн тэнд)

Хүснэгт 2. Хуучин болон шинэ нийгмийн төлөөлөлд хандах байдал

Зохиолч хуучин нийгэмд шүүмжлэлтэй хандаж, шинэ нийгэм журмыг сайшаан харах байдлаа гэлэн Дамдин, мээрэн Санж болон эвлэлийн гишүүн Цэрэнгийн дүртэй эсрэгцүүлэхийн зэрэгцээ тухайн баатарт хандаж буй дүр болон хам олны байдлаар илэрхийлсэн байна. Жишээ нь гэлэн Дамдин, Санж мээрэн зэрэг хуучин нийгмийн төлөөлөлд хандах үзэл санааг Хас-Эрдэнийн өчил-дотоод хүүрнэл, сэтгэл зүйн байдлаар гаргасан бол харин шинэ нийгмийн төлөөлөл, эвлэлийн гишүүн Цэрэнгийн тухай өгүүлэхдээ хуучин нийгмийн төлөөлөлтэй эсрэгцүүлж, бусдын хүндлэлийг олсон, тухайн хүний үг бусдад нөлөөлөх чадвар өндөртэй буйгаар хуучин нийгмийн эрх мэдэл алсран унаж, шинэ нийгэм журмын хүчтэй болж буйг үзүүлжээ.

Нийгэм, улс төрийн хам сэдэвтэй холбогдох дараагийн зүйл нь зохиолын дүрд ятгалгын аргаар нөлөөлж буй байдал юм. Зохиолд шинэ нийгмийн төлөөлөл Хоролмаа, хуучин нийгмийн төлөөлөл Занданбал хоёул ятгалгын аргыг ашиглан Хас-Эрдэнэд нөлөөлж буйгаас улбаалан хуучин нийгмийн хор хөнөөл, шинэ нийгмийн давуу талыг харуулсан байна. Уг санааг зохиолд тусгахдаа нийгэмд үүрэг, улс төрийн ухаан мэдрэлтэй бүхий Хоролмаа гол дүр Хас-Эрдэнэд ирээдүйн сайн сайхан, тогтвортой байдал эсвэл айдсаар, харин соёл боловсрол эзэмшээгүй хуучин нийгмийн төлөөлөл Занданбал шууд ашиг амлах замаар ятгалгын арга ашиглан нөлөөлж буйг доорх хүснэгтээс харж болно. Шинэ нийгмийн төлөөлөл болох Хоролмаа Хас-Эрдэнэд нөлөөлөхдөө ирээдүйн сайн сайхан болон удалгүй тохиолдож болох аюулыг тоочин айдас бүтээх замаар ятгадаг. Зохиолын өрнөл

хэсэгт “...чөлөөт өдрүүдэд Хоролмаагийн гэрт ирж, үргэлжид зөв сайн заавар сануулга ба сургамжийг авдаг” (Мөн тэнд: 226) Хас-Эрдэнэ Занданбалыг дагаж, таван гудамжнаа шинэ байшин босгож, биеэ үнэлэн хөдөлмөр эрхэлж эхэлдэг. Хоролмаа Хас-Эрдэнийн байдлыг нүдээр үзэж, “...үнэнхүү сэтгэлээс хайрлан санаж, зөөлөн эелдэг үгсээр зөв үнэн сануулгыг ятган...” (Мөн тэнд: 229-230) хэлдэг. Хас-Эрдэнэ түүний үгийг үл хэрэгсэхэд Хоролмаа доорх байдлаар ирээдүйн уршгийг тоочин ятгадаг. Үүнд:

Хэрэв чи сургуульд сурах дургүй бол зохих ханийг түшиглэн амьдрах хэрэгтэй. Ер ийм жигшүүрт байдлаар олонтой самуурах аваас наанадаж бие махбодод чинь хор олж, эрэмдэг зэрэмдэг болох төдийгүй эцэстээ ганц бие буурайгаар мөхөхөд хүрнэ... хань үгүй эцэстээ тэжээлгэх үргүй, гэрт орвол хүйтэн гэдсэн дотор өсгөлөн, гэмгүй атал хараагдаж, зэмгүй атал жигшигдэж, хөөрхөн гоо царай чинь хөгшин бухын мэт үрчийж, нарийн гол шиг бие чинь хохь цагаанаар хатаж... өрөвдөж туслах өршөөлгүй өнөд гутамшигийн туйлыг хүлээж, өндөр хогийн өвөр, өргөн зээлийн булан өмхөрсөн хүрдний ёроолыг хэсэж хэвтэх цагт ... (МӨТД, 2015: 230).

Хас-Эрдэнийн биеэ үнэлэх байдлын хор уршгийг шинэ нийгмийн төлөөлөл болох Хоролмаа тоочин өгүүлэхдээ бие махбод, нийгэмд эзлэх байр суурь, хүний суурь хэрэгцээгээ үл хангаж чадах ирээдүйн тухай айдас бүтээн сануулж буйгаараа онцлог юм.

Мөн хэсэгт нэгэн сонирхолтой зүйл ажиглагдаж байгаа нь эмэгтэй дүрийг гэр бүлтэй болгох тухай ятгалга юм. Хас-Эрдэнэ, Хоролмаа нар нэгэн нутгаас хамт гарахдаа эрдэм боловсрол эзэмших хүсэлтэй байсан ч Хас-Эрдэнэ анхдагч зорилгоос гажиж, биеэ үнэлэн амьдрах болсонд Хоролмаа түүнд зохих ханийг олж, тогтвортой гэр бүл зохиох саналыг хэлдэг. Уг ятгалгаас Хоролмаа шинэ цагийн нийгэм, нийгэмд хэрэгжүүлсэн тодорхой бодлогын нөлөө бүхий дүр болохыг харж болно. Мөн уг зүйл ятгалгатай хамт уг ажил үйлийг цаашид эрхэлбэл нийгэмд эзлэх байр суурь уруудаж, *маргинал⁴ хэсгийн нэгэн болно гэсэн санааг гаргажээ. Үүнээс ажиглан үзвэл Хоролмаа Хас-Эрдэнэд боловсрол эзэмшихийн ашиг тус, тогтвортой гэр бүлийн талаар ухуулж, биеэ үнэлэхээс үүдэх хор уршгийг таниулж байгаа зэрэг нь нийгмийн зүгээс эмэгтэйчүүдэд чиглэж байсан бодлогыг зохиолоор дамжуулан илэрхийлсэн нэгэн зүйл юм.*

“Гурван хүүхэн” зохиолд шинэ цагийн эмэгтэйн дүртэй хариуулан хуучин нийгэм журмын төлөөллийг Занданбалын дүрээр бүтээсэн байна. Туужид Занданбалыг нутгаас гарч хотод суурьшсан бүсгүй хэмээн өгүүлдэг ч өмнөх нийгэм журам, “хуучин” хүрээний төлөөлөл болдог. Занданбал Хоролмаад хандан “...Мөд их юмтай болно. Чи сургууль мургууль гэж дэмий завхарсны

⁴ Маргинал байдлын үзэл. Виола Клейн анх энэ үзлийг дэвшүүлсэн бөгөөд маргинал байдал гэдэг бол хоёр өөр ертөнц, хоёр өөр соёлд нэгэн зэрэг амьдарч байгаа хүний байдлыг илэрхийлдэг. Энэхүү хоёр өөр соёл, өөр ертөнцийн нэг нь нөгөөгөө давамгайлсан, дарангуйлсан, нөгөөгөөс дээгүүр шинжтэй. Өргөн хүрээгээр авч үзвэл маргинал байдлын үзэл бол оршихуйн контекстэд яригдах зүйл, зөвхөн эмэгтэй хүнд хамаатай асуудал биш, харин зүй бус, тэгш биш байдал, мөлжлөг дарлалын улмаас зовж шаналж байгаа бүх хүнд хамаатай асуудал юм (Отгонбаяр ба бусад., 2023: 103-104).

хэрэггүй. Харин зүгээр эртхэн энд нэг байшин засаж алт, сувд торго, дурдмаар биеэ тордож, эрт унтаад орой босож, эрх дураараа жаргаж байхаас сайхан юм хаана байх вэ хэмээн ятган ухуулна” (МӨТД, 2015: 228). Өмнө дурдсанчлан шинэ нийгмийн төлөөлөл Хоролмаагийн үйлдэл, амлалт болоод ятгалга нь ирээдүйн сайн сайхан, тогтвортой байдалд чиглэж байсан бол Занданбал өнөө, удахгүй тохиох ойрын ирээдүйд өгөх ашигийг тоочин өгүүлж Хас-Эрдэнийг ятгаж байна.

Дээрх санааг нэгтгэн үзвэл шинэ нийгмийн үзэл санаа, эмэгтэйчүүдэд чиглэсэн суртал ухуулга нь ирээдүйн тогтвортой байдал, урт хугацааны сайн сайхныг ухуулахын зэрэгцээ мөн Занданбалын үхлээр айдас бүтээх замаар нөлөөлж буйг зохиолд Хоролмаа Хас-Эрдэнийг ятгаж буй ятгалга болон зохиолчийн хүүрнэлээс харж болно. Харин нөгөө талаас хуучин нийгмийн ятгалга нь зөвхөн богино хугацааны ашиг амлаж байна. Эндээс зохиолч шинэ нийгмийг сайшаан харж, хуучин нийгмийг шүүмжлэн бичсэн нь тодорхой байна.

III. Эмэгтэйчүүдийн хам сэдэв

Уран зохиолын бичвэрт хүйсийн шинжлэл хийхдээ эр, эм хүйсийг физиологи болон биологийн талаас хэрхэн дүрсэлсэн, хүйсийн харилцаа холбоог зохиол бүтээлд хэрхэн гаргасныг шинжилж, үүнд тулгуурлан нийгмийн бүтцийг тодорхойлохыг зорьдог (Райан, 2018: 160). Уг хэсэгт бид хүйс, жендерийн харилцаа холбоог зонхилон авч үзэхийн зэрэгцээ зохиолд эмэгтэй биеийг хэрхэн ашигласан тухай дэлгэрүүлэн тайлбарлана.

Хүйсийн тодорхойгүй байдал, хөдөлмөрийн хуваарь. Адуу манах, үнээ саах зэрэг уламжлалт соёлын хөдөлмөрийн хуваарь нь жендерт суурилдаг. Харин зохиолын эхэн хэсэгт Дугар өвгөнийд хот айлын хонины хишиг өдөр таарч, бага охин Хас-Эрдэнэ хонь хариулж байдаг. Хонь хариулах хөдөлмөр нь тодорхой утгаар тухайлан нэг хүйсийг заахгүй, төвийг сахисан шинжтэй (*gender neutral*). Үүнээс улбаалан тухайн зохиолын эхэн хэсэгт гол дүр Хас-Эрдэнийг гэрээс гарахаас урьд эмэгтэй хүйсэд үл харьяалагдах, саармаг байдлаар дүрсэлсэн гэж болох юм.

Эцгийн гэрээс гарах ба эмэгтэйчүүдийн чөлөөт байдал. Уламжлалт монгол соёлд охид үсээ хагалан, хоёр салаа болгож, хадмын галд мөргөхөөс өмнө төрсөн гэр, тэр дундаа эцэгт харьяалагдаж, эмэгтэй хүн эцгийн гэрээс гарах нь айлд бэр болохоос бусад тохиолдолд боломжгүй байжээ. Харин “Гурван хүүхэн” зохиолд уламжлалт соёл заншил шинэчлэгдэн, тодорхой бие хүн соёлын хүлээснээс мултарч буйг Хас-Эрдэнэ ураглахаас өмнө эцгийн гэрээс гарч, суралцахаар явж буйгаар үзүүлжээ. Гэвч нөгөө талаас эмэгтэйчүүдийг гэр ахуйн хүрээнээс татан, нийгмийн тавцанд гаргаж буй уг өгүүлэмж нь өрөөл шинжтэй болохыг Хас-Эрдэнэ хотод суралцах шийдвэрийг түүний эцэг гаргахдаа эргэлзэх, Санж мээрэн, Дугар гэлэн, гишүүн Цэрэн нарын эрэгтэй дүр, баатрын дуу хоолой нөлөөлөх шинжтэй байгаагаар нотолж болно.

Хэдий зохиолд эмэгтэй хүн бие даан гэрээс гарч суралцах боломжийг олгож буй дэвшилтэт санааг тусгасан боловч зохиолын төгсгөлд гол дүр Хас-Эрдэнэ дахин гэр ахуйн хүрээнд ордог. Хас-Эрдэнэ Занданбалыг даган биеэ үнэлэх болсонд Хоролмаа зохих ханийг түшин амьдрах хэмээн ятгадаг. Үүний зохиолын төгсгөлд Хас-Эрдэнэ “... намын гишүүн сургуулийн багш Мандах лугаа амраглан

хамтарч, үүд өрхийг гийгүүлэн улсдаа хайрлагдав” (МӨТД, 2015: 233) хэмээдэг. Энэхүү жишээг шинжлэн үзвэл анхлан эцгийн эрхт ёс бүхий гэр ахуйн хүрээнээс гарч, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох болсон дүр дахин улсдаа хайрлагдан, нийгэмд эзлэх байр сууриа олж авахын тулд зохих ханьтай суух хэрэгтэй болж байна. Эндээс зохиолч дүрийг дахин гэр бүлийн хүрээнд татан оруулж, эмэгтэй дүрийн бие даасан байдалд итгэлтэй бус байгаагаа харуулжээ.

Эмэгтэй объект ба эрэгтэй субъект. Зохиолч М.Ядамсүрэн “Турван хүүхэн” тууждаа нэгэн нийгэм өөрчлөгдөж, шинэ нийгэм журам тогтож буйг эмэгтэй бие, эмэгтэй объект дээр дөрөөлөн илэрхийлсэн байна. Тухайн нийгмийн үйлдлийн үр нөлөө зохиолын эмэгтэй дүрийн биед зонхилон илэрч буйгаар уг санааг баталж болох юм. Өмнөх хэсэгт нийгэм, улс төрийн хам сэдвийг тайлан тайлбарлахдаа зохиолч хуучин нийгмийн байдлыг Занданбал, шинэ нийгэм журмыг Хас-Эрдэнийн дүрээр төлөөлүүлсэн болохыг дурдсан бөгөөд энд илүү дэлгэрүүлж байна.

Хуучин нийгмийн хувь хүнд үзүүлэх нөлөөг Занданбалын биед тусган үзүүлсэн байна. Туужид Занданбал хүрээний хятадуудад биеэ үнэлж, тодорхой хөдөлмөр эрхэлсний улмаас “... хамар ам нь улаан цоохор яр болоод” (МӨТД, 2015: 232) үнэр хийгээд үзэгдэл үнэхээрийн гутамшиг болсон тухай өгүүлдэг. Уг хэсгээс хуучин нийгмийн үйлдэл, тэр дундаа эрэгтэй субъект (хятад наймаачин гм.)-ын алив үйлдлийн үр дагавар эмэгтэй биед яр шарх, өвчин зэрэг тодорхой биет байдлаар тодрон гарч ажиглаж болно. Эр хүйсэд харьяалагдах хуучин нийгмийн үйлдэл дан ганц эмэгтэй биед физик утгаар нөлөөлөөд зогсохгүй бүр тухайн биеийг эзлэн үгүй болгож буйг доорх жишээнээс харж болно.

... Занданбалын байшинд ирвээс өөр хүн суусан байх тул Занданбал хаа нүүснийг асууваас хойт есөн гудамжны хойно хэмээх тул тэр зүг явж эвдэрхий, яндантай элдэв олон овоохой хэсэж сураглаваас тэр баруун тал дахь хогийн нөмөр дэх овоохой бололтой хэмээн заах тул очиж үзвээс Занданбал хэдий нь үхэж, үрэгдсэн нь тэр гэх тэмдэггүй хэдэн хэрзгэр яс болоод овоохой нь нурж унасан байна (МӨТД, 2015: 234).

Дээрх хэсгээс тухайн хуучин нийгэм улбарин хувьсаж, шинэ нийгэм тогтохыг хуучин нийгмийн эзэлж байсан объект тэр гэх тэмдэггүй замхран алга болсноор дүрсэлсэн юм. Хуучин нийгмийн үйлдлийн үр дүн эмэгтэй биед физик байдлаар тусаж буй бол шинэ тутам тогтож буй нийгэм журмын нөлөө эмэгтэй биед сэтгэл зүйн дарамт, гэмтэл байдлаар илэрч байна. Жишээ нь Занданбалын адилаар биеэ үнэлж байсан Хас-Эрдэнэ Занданбалыг өвчин олсныг мэдэж, “... энэ өдрийн гутамшигт байдлаас эргэн эргэн жигшиж, эдүгээ даруй Хоролмаагийн хормойноос зуурч зөв замдаа орохыг яаран довтлон санана” (Мөн тэнд: 232) хэмээн өөрийн өмнөх үйл байдлаас няцаж, шинэ нийгмийн зөв гэж хэлж буй замд орохыг тэмүүлж буйгаар илэрхийлжээ.

Туужийн төгсгөлд Хас-Эрдэнэ Хоролмаагийн заавраар явж, хуучин нөхөр Занданбалыг эрэн олоход, хэдийн үхэж, тэр гэхийн тэмдэггүй хэдэн хэрзгэр яс болсныг хардаг. Энэ үед “Хас-Эрдэнийн сэтгэл улам эвдрэн урьдын гэмшилт байдлаа дахин нотод жигшин санав” (Мөн тэнд: 234) хэмээсэн нь шинэ нийгмийн гишүүн болсон эмэгтэйд идэвхгүй байдлаар үйлдсэн хуучин цагийн үйл сэтгэл

зүйд нөлөөлж буйг харж болно. Хуучин болоод шинэ нийгмийн идэвхтэй үйл бүхий эр хүйсэд хамаарах субъектийн үйлдэл нь эмэгтэй хүйсийг объект болгож, тухайн дүрд бие махбодын болоод сэтгэл зүйн байдлаар нөлөөлж байгааг дээрх жишээ нэрээр батлах юм.

Эмэгтэй бие ба үндсэрхэг үзэл. Антропологич У.Булаг эмэгтэйчүүд, эрлийз болон үндэсний үзлийн тухай холбон авч үзэхдээ эмэгтэйчүүдийн үндэстэн-улсад гүйцэтгэдэг уламжлалт үүргийн талаар дурдсан байна. Тэр бээр “Монгол үндэстний эхийн хувьд эмэгтэйчүүд монгол үндэстний үр удам, соёл зэргийг үргэлжлүүлэх үүргийг хүлээдэг” (Булаг, 2016: 135) хэмээжээ. Үндсэрхэг үзэл нийгмийн дахин үйлдвэрлэлийг чухалчилдаг учир эмэгтэй хүний нөхөн үржихүйг чухалчилж, эмэгтэйчүүдийг тодорхой хүрээнд хязгаарладаг. Харин зохиолч уг санааг сөргүүлэн тавьж, уламжлалт байдлаар гэр бүл зохиолгүй, биеэ үнэлэх нь ямар үр дүнд хүрч байгааг Хас-Эрдэнэ, Занданбалын дүрээр дамжуулан харуулсан. Ингэхдээ “...самуун сүргийн худалдаачид хятадууд” (МӨТД, 2015: 229)-тай буюу хүч бүхий харь соёлын гишүүн, өрөөл шинжтэй нэгэнтэй бэлгийн харилцаанд орж, шинэ нийгэм, үндэстэн улс байгуулахад заналхийлж байсан нийгмийн үзэгдлийг шүүмжилсэн байр сууриа зохиолч илэрхийлжээ.

Хүчинд автан өөрийн биеийг эзэмдүүлж буй эмэгтэйн байдлыг туужид Хас-Эрдэнэ архинд балартан унтсаны хойно “... Занданбал Хас-Эрдэнийг согтсоныг бодохгүй тэдгээр иргэд лүгээ үнэ хэлэлцэн битүү цагаан хөшигний дотор ээлжээр оруулна” (Мөн тэнд: 228) хэмээн хүүрнэдэг. Уг бусдын хүчинд ухамсаргүй автаж буй эмэгтэйн биед дөрөөлөн шинэ тутам байгуулж буй үндэстэн улс, тухайн үндэстэн улсын цөмийг бүрдүүлэх монголчуудад заналхийлж буй харийн өрөөл (*other*) нийгмийн бүлгийг товойлгон гаргасан байна. Энэхүү дүрслэлийн жишээ нь Их Британийн колоничлолоос гарч, шинээр тусгаар тогтносон Энэтхэгийн газрын зургийг боолчлогдсон янхнаар дүрсэлсэн байдлыг улс төр, эдийн засгийн орчинд өөрийн “дотоод колоничлол”-ын учрыг олж байгаар үзүүлсэн (Булаг, 2016: 139; Spivak, 1992: 99) тухай Спивакын тайлбарыг санагдуулах бөгөөд тодруулж хэлбэл, монголчууд үндэстэн улс байгуулахад хүлээсэн олон зүйл эрсдэл, гадаадын ноёрхлын сүүдрийг үзүүлэхдээ зохиолч эмэгтэй хүний биеийг ашигласан байна.

Эрэгтэй харц ба зохиолч. Эмэгтэйчүүдийн болон зохиолчийн хам сэдэвт зэрэг хамаарах нэгэн жишээ нь зохиолд эмэгтэйчүүдийг дүрслэн үзүүлж буй харц, түүний харах өнцөг юм. Британийн феминист кино онолч Лаура Мюлвей “Харааны таашаал ба хүүрнэл кино”(1975) өгүүлэлдээ анхлан “эрэгтэй харц (*male gaze*)” хэмээх ойлголтыг танилцуулсан. Камер болон үзэгч нь эрэгтэй хүйстэй, гол дүрийн шинжтэй агаад хүүрнэлийн доторх хүслийн объект нь идэвхгүй эмэгтэй хүйстэй байдаг хэмээжээ (1999: 837). Уг санааг зохиолд тусган ашиглавал хүслийн объект болох эмэгтэй дүрийг эрэгтэй хүйстэй субъект буюу зохиолч туурвин бичиж, өөрийн хараан дор дүрсэлж буй хэмээн тайлбарлаж болно. Зохиолд “... Занданбал өөрөө хөгшин залуу хэд хэдэн хятадуудтай хэд дахин дараалан өндөр толины өмнө нүцгэнээр загас наадуулах арван гурван зүйлийн явдлыг үзүүлнэ” (МӨТД, 2015: 228) гэж дүрсэлсэн (*descriptive*) нь зохиолч өөрийн хүйсэд хамаарах харцаар эмэгтэй дүрийг ухамсар бусаар хүслийн объект болгон харж буй гэж давхар хэлэлцүүлж болох юм.

Эмэгтэйчүүдийн хам сэдэвт хамаарах өмнөх зүйлсийг нэгтгэн үзвэл эцгийн гэр байхдаа жендерийн хувьд нейтрал (*neutral*) байсан дүрийг нийгэм, эдийн засаг, хөдөлмөрийн харилцаанд татан оруулж ирэхдээ бие даасан субьектив байдалгүй, бусдын шийдвэрийн объект болгож, нийгмийн алив нэгэн үзэл суртал, хэв журам, үндсэрхэг үзлийг тулгуурлан босгох “эмэгтэй бие”-ийг ашиглан дүрсэлжээ.

IV. Соёлын хам сэдэв

М.Ядамсүрэнгийн “Гурван хүүхэн” туужийн соёлын хам сэдвийг шинжлэн үзэхэд өөрийн үндэсний соёл хийгээд харийн соёл, шинэ болон хуучин соёлыг дүрслэн үзүүлж, уг хосмолжин эсрэгцэл дунд зууч болж буй соёлын эд зүйлсийг дурдсан байна. Уг санааг уламжлалт соёл, идээ ундааны болон тээврийн хэрэгслийн жишээнд тулгуурлан тайлбарлах юм. Туужийн эхлэлд зохиол өрнөх газар орны нийтлэг мэдээллийг өгөх байгалийн зураглалд монгол соёлын хам сэдэвт хамаарах зүйлсийг тодорхой дурдсан байна.

Саруул сэргэлэн дэлгэр талбай нутагт айл өрхөд, хот саахалтаар салбарлаж буудаллаж, тэрэг чингэлэг угсраад унага тугал зэллэж, идээ цагаа дэлгээд, хурга, ишиг хүүхэд багачууд нь гадуур орчимдоо бужисналдан энд ч айраг исгээж тэнд ч архи нэрээд, Даваа даага сургаж, Бадам бяслаг шахан, Дулмаа үнээ сааж, Дугар тэрэг засан адуу хонийг ээлжээр хариулан, аян жинд хамтран явцгааж... (МӨТД, 2015: 2019)

Уг хэсэгт тал нутгийн нүүдэлчдийн зун цагийн хөдөлмөр, идээ цагаа боловсруулахаас аваад унаа хөсөг бэлтгэх, жин тээх тухай соёлын хам сэдэвт хамаарах зүйлийг өгүүлж, зохиолын орчин, байгалийн зураглалыг туурвисан байна. Мөн үүнтэй зэрэгцэн идээ цагаа боловсруулах зэрэг гэрийн доторх ажлыг эмэгтэйчүүд, тэрэг засах, даага сургах зэрэг ажлыг эрэгтэй хүн гэрээс гадуур гүйцэтгэж байгаа уламжлалт хөдөлмөрийн хуваарийг ажиглаж болно.

Зохиолд гарах хоол, идээ ундааны соёлын хам сэдэв нь өөрийн хийгээд бусдын, таатай хийгээд таагүй соёлын илэрхийлэл болжээ.

Хас-Эрдэнэ өөрийн соёлын хилээс бусдын соёлын хил рүү нэвтэрч буйг идээ ундаа, хоолыг өрж тавагласан байдлаар дамжуулан дүрсэлсэн байна. Туужид анхлан Занданбалын гэрт ирэхэд Баяндай хятад гуанзнаас хоол авчран дайлдаг. Энэ талаар доорх байдлаар бичжээ.

... тийн байтал мөнөө өвгөн хятад хоёр хятадаар нээжгээд дүгрэг модон бүрхүүлтэй юм авхуулан ирсэнд Занданбал босоож, байшингийн төв дунд ширээ сандлыг засав... тэрхүү авчирсан дүгрэг саваа нээж дотроос нь өдий төдий олон таваг дийз, савх, ногоо тэргүүтнийг зайгүй өрж бас хэд хэдэн лонхтой улаан цагаан архиыг гаргаж жагсаан тавив (МӨТД, 2015: 227).

Зохиолчийн хүүрнэлээр дүрийн ажин буй танил бус соёлын илэрхийллийг дурдсан нь монголчуудын тавгийн идээ тавих ёстой эсрэгцдэг. “Монгол айлын зочлох ёсыг ёслол хүндэтгэлийн зэргээр нь цай чанах, таваг тавих, тос холих,

тэвш тавих, сархад сөгнөх гэсэн 3-5 үе шаттай” (Нандинбилиг, 2022: 170) агаад цагаан, хөх, шар, улаан болон хар идээг зочинд дээжлэн барих тогтсон ёстой хэмээн үзвэл уг туужид дүрслэгдэх энэхүү идээ хоолны дүрслэл нь уламжлалт соёлтой эсрэгцэн, тогтсон дарааллаар бус хольж зассан, тэр дундаа хөх ногоон ба хар идээ хэмийг хэтийдүүлэн голчилсон шинжтэй байна. Энэ нь нэг талаар гол дүр Хас-Эрдэнэ өөрийн соёлын хилээс шинэ харь соёлын хилд нэвтрэх байдлыг үзүүлжээ.

Уг санааг лавшруулах нэгэн зүйл нь монголчуудын төдийлөн ашигладаггүй хоолны хэрэгсэл болох савх, дийзийг дурдан, харийн соёл тэр дундаа хятад соёлын илэрхийлэл болгон дүрсэлсэн байна. Зохиолч амтлах мэдрэхүйгээр дамжуулан тухайн дүр нэгэн соёлын хил хязгаарыг давж, бусдын соёл руу нэвтэрч буй байдлыг давтан үзүүлж, тухайн соёлын таатай хийгээд таагүй үнэлэмжийг илэрхийлсэн байна. Туужид “...Хас-Эрдэнэ аргагүй хамт идэх боловч зарим нь гашуун тул сэжиглэнэ. Зарим нь сайхан тул дахин дахин иднэ. Ширээн дээр мах ногооноос эхлэн өндөг, загас, өт хорхой хүртэл байгаа тул урьд өмнө үзэж амсаагүй сонин зүйлүүдийг Хас-Эрдэнэ сонирхон гайхан идэж” (МӨТД, 2015: 227) хэмээсэн нь таатай хийгээд таагүй үнэлэмжийн илэрхийлэл болдог. Зохиолын дүр бусдын соёлын зарим өнгө идээнд амтших ч заримыг эс таалах, төдий л хүнсэнд хэрэглэдэггүй домог зүйн доод тивийн амьтан өт хорхойг хоолонд орсныг харах нь бусдын соёлтой шинэ тутам тулгарах, түүнд таатай болоод эс таатай хандахыг харах хийгээд амтлах мэдрэхүйд нөлөөлөх байдлаар бичжээ.


Туужийн удаах хэсэгт бусдын соёлд өөриймших байдлыг туйдуу дан гэх хоолоор дамжуулан илэрхийлсэн байна. Архины шарт бие тавгүйрхсэн Хас-Эрдэнэд Занданбал туйдуу дан гэх хоолыг өгч, “... Хас-Эрдэнэ авч идвээс бяслаг мэт цагаан дөрвөлжин юм хийсэн маш сайхан амттай шөл тул дуртайяа идэв. Түүнээс үнэхээр дотор нь нэлээд амар болсон шиг санагдана” (МӨТД, 2015: 228). Уг хэсэгт хоолоор дамжуулан бусдын соёлын босгыг алхсан нэгэн тухайн соёлын идээ ундааг өөрийн соёлын буюу эвлүүлж шахсан цагаан идээний зүйл бяслагтай адилтган таашааж, сайшаан идэж буй нь төрөлх соёлтой бусдын соёлыг ижилдүүлэн сэтгэж, өөриймших байдлыг товойлгон гаргажээ.

“Турван хүүхэн” туужид нүүдлийн болон суурин иргэншлийн ялгаа заагийг тээврийн хэрэгслээр харуулж, тухайн соёл иргэншлийн нөлөөг дүрээр дамжуулан гаргасан байна. Анх Хас-Эрдэнэ, Хоролмаа нар хөдөө гэрээс хотыг зориход “... нэжгээд морь унаж бас нэгэн морь ачаад аймаг хүртэл өвгөн Адъяагаар хүргүүлэн морьдоо буцаах хэмээж гурвуулаа дөрвөн морьтой умард зүг чиглэн” (МӨТД, 2015: 223) явдаг. Ачилга, уналгын гол хэрэгсэл болох морь нь зохиолд уламжлалт соёлын төлөөлөл болж байна. Харин суурин соёл иргэншлийг машинаар дамжуулан илэрхийлжээ. Уг санааг зохиолд удаах байдлаар дүрсэлсэн байна.

... залуу охин Хас-Эрдэнэ машин дээр суухдаа дэмий л их баярлана. Бас түүний сүрлэг дуу ба үл мэдэгдэх утаа үнэрээс сэжиглэн айна. Машин түр тар хэмээн дуугаран үе үе аймшигтайгаар хаихиран дуугарахад Хас-Эрдэнийн бие жирс хийж үс өрвөсхийх мэт цочих боловч тэр даруй ганцаар өөртөө инээнэ (Мөн тэнд: 224).

Уг хэсгээс ажиглан үзвэл дассан уламжлалт ахуйгаас гарч, аж үйлдвэрлэл бүхий нийгэмд шилжиж буйг машинаар бэлгэдэн үзүүлж, шинэ соёлтой тулгарах мөн иргэншлийн бие хүнд үзүүлэх нөлөөг сэжиглэн айх, бие эржигнэн инээх зэрэг сэтгэл зүйн тодорхойгүй, үл мэдэх хуваагдмал байдлаар өгүүлжээ.

Үүний зэрэгцээ зохиолд нэгэн зүйл тээврийн хэрэгсэл болох унадаг дугуй хоёр удаа дурдагддаг. Анхлан Занданбалтай учрахад дурдам дээл өмсөж, дугуй унасаар айсууг хардаг. Мөн Хас-Эрдэнэ, Хоролмаа нар ажлын чөлөөгөөр унадаг дугуй жийн, Богд уулнаа зугаалахаар очдог. Эндээс ургуулан үзэж, зохиолд хагас автомат тээврийн хэрэгсэл болох унадаг дугуйг эерэг болоод сөрөг үнэлэмжгүй дурдаж буй нь нүүдлийн болон суурин соёл иргэншлийн тээврийн хэрэгслийн зууч⁵, зөрчлийг амжилттай шийдвэрлэх тээврийн хэрэгсэл байдлаар дүрсэлжээ гэх санааг дэвшүүлэх боломжийг олгож байна (Бүдүүвч 1).



Бүдүүвч 1. Соёл иргэншлийг илэрхийлэх тээврийн хэрэгсэл

Мөн зохиолд хуучин болон шинэ нийгэм, анагаах ухаанаар илэрхийлж, хуучин нийгмийн сул талыг шинжлэх ухааны ололтоос зайлсхийж буйгаар өгүүлсэн байна. Зохиолын төгсгөл хэсэгт Занданбал өвчин олж, элдэв зүйлийн улаан яр биеэр туурсан тухай өгүүлдэг. Анх Занданбалыг өвчилсөн даруй “... олон хүн зэрэг зэргээр үргэлж очиж, түүний биеийг сувилах ба хятад дайпа эмчээр эмчлүүлэн”(МӨТД, 2015: 231) тусыг эс олох тул “... хятад эмчээс элдвээр эмнэж агсаар харин хэсэг хэсэг салбарласан яр болж, аль эмзэг газраар шавсан тул үнэр, үзэгдэл үнэхээрийн гутамшиг бөгөөд орчим хүн ойртохуйяа бэрх болжээ” (Мөн тэнд) хэмээдэг. Уг хэсэгт хүрээний хуучин соёлын төлөөлөл болох хятад эмчээр эмчлүүлсэн ч өвчин улам газар авч буйг харж болно. Мөн хүрээний хятадын нэгэн соёл болох хар тамхины эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг “... урьд мөнөө завхарч ахуйдаа хар тамхи татаж сурсан нь одоо мөн нэгэн төрлийн илүү өвчин болж, ямагт хар тамхины “жин” хэмээх хөдөлж, өвчтэй бие давхар зовлон эдэлнэ” (Мөн тэнд) хэмээн дүрийн бие махбодод илрэх нэгэн зовуурь байдлаар үзүүлсэн байна. Зохиолч хятад, төвөд эмнэлгээр дамжуулан хүрээний хуучин соёлыг төлөөлүүлж, үүнтэй шинэ цагийн соёл болох европ эмнэлгийг сөргүүлэн тавьжээ. Туужид “... Занданбал хагас жил шахам ийм муухай өвчинд зовсон атал ер европын боловсон эмнэлгээр үзүүлэхийг тун анхаарч санасангүй ба түүнийг урьдын нөхдөөс сануулсангүй тул тэрхүү өвчнийг төвөд ба хятад эмнэлгээр хэчнээн эмчлүүлэвч ер хэрхэн эдгэх аж” (Мөн тэнд) гэснээс тодорхой

⁵ Леви-Стросс бүхий л домог эсрэгцлийг ашигладаг бөгөөд тэдгээрийг алсуур хуулбарлан үгүйсгэх явдал руу, эсвэл зуучлал руу тэмүүлдэг гэдгийг анхааралдаа авах нь зүй хэмээсэн байдаг. Энэхүү арга зүйгээр домгийг авч үзвэл зөрчил дундын зуучтай, эсвэл зуучгүй хэрхэн саармагжиж байгааг ажиглах боломжтой (Стросс, 2013). Хосмолжин эсрэгцлийн голд байх зуучлагчийн жишээгээр дайн болон газар тариалангийн дунд дайны ургац хураалт болох хуйх, байгалиас соёл руу шилжихэд хувцас, үнс хөө нь гал голомт (газар), дээврийг (тэнгэр) нэгтгэж байдгийг дурджээ.

харж болно.

Тухайн дүрийн шийдвэрт хүрээний хуучин соёлын зүйл дээр шашны итгэл бишрэл хоймсон нөлөөлж, европын анагаах ухаанаас татгалзаж буйг дараах байдлаар тодорхой өгүүлдэг.

Маргааш өглөө нь Хас-Эрдэнэ ирж докторт аваачъя хэмээсэнд Занданбал нэгэнт феодал лам нарын балар суртлын будангуй ухуулгад бүрнээ автагдсан болох тул доктор хэмээх нэгэн үгнээх их л айж, доктор гэдэг чинь хатгах, огтлох зэрэг аюултай хэцүү улс гэж сонссон. Би очихгүй. Ингээж байгаад үхнэ хэмээн огт зөвшөөрөхгүй (Мөн тэнд: 233).

Уг хэсгийг ажин үзвэл нэгэн талаас шинэ нийгмийн соёл, мэдлэг, анагаах ухаанаас сэтгэл хөдлөл, айдаст автан татгалзаж буй дүрийг харж болох бол нөгөө талаас зохиолчийн хүүрнэлээр дамжуулан тухайн цагийн хуучин анагаах ухаан, шашны мэдлэгийг буруушаах үнэлэмжийг хоймсон илэрхийлж байна.

V. Эдийн засгийн хам сэдэв

“Гурван хүүхэн” туужийн гол дүрүүдэд зайлшгүй нөлөөлж буй нэгэн зүйл нь дүр баатрын хөдөлмөрийн харилцаа юм. Зохиолын өрнөл хэсэгт Хас-Эрдэнэ Занданбалын дадуулан дасгах аргад орж биеэ үнэлж эхэлдэг. Энэхүү далд эдийн засгийн харилцаа нь дүр, баатрын эрх мэдэл, хүчний харилцааг илэрхийлэх нэгэн чухал сэжиг болж байна.

	Занданбал, Хас-Эрдэнэ	Хятадууд
Тоо	Ганц	Олуул
Солилцооны хэрэгсэл	Биеийн капитал	Мөнгөн хөрөнгө, эд зүйл
Эрх мэдлийн байдал	Шууд захирах босоо чигт эрх мэдэл	Дам нөлөөлөх хэвтээ чигт эрх мэдэл

Хүснэгт 3. “Гурван хүүхэн” туужийн эдийн засгийн харилцаа

Зохиолын гол дүр Занданбал, Хас-Эрдэнэ нар нь тодорхой солилцооны биет хэлбэргүй, өөрийн биеийн капиталыг хятадуудтай бэлэн мөнгө болон эд зүйлээр худалдан солилцдог. Тухайн дүр өөрийн биеийг өмчлөн мэдэх тул хятадуудыг шууд захирах, босоо чигт эрх мэдэлтэй байгааг зохиолд Занданбал “... буурал сахалтай хошууг ойртуулан авчирч чанга үнсээд, Баяндай чи яваад гуанзнаас сайн хоол дуудаад ирэхгүй юу хэмээсэнд өвгөн хятад ханасан баярласан байдлаар...” (МӨТД, 2015: 227) хэмээн бичсэнээс тодорхой харагдаж байна. Нөгөө талаас зохиолд дурдагдах хятадууд нь мөнгө болон эд зүйлд тулгуурласан хам олны хэвтээ чигт эрх мэдэлтэй байдаг. Уг санааг хятад наймаачид Занданбал, Хас-Эрдэнийг нэгэн зэрэг олон талаас эд зүйлээр хангах байдлаар өгүүлж, “...Буянт будаа авчирч, Далай давс нийлүүлэн мужаан түлээ буулгаж, сайван дээл авчран, Өндөр өндөг хүргэж, Цоохор ногоо нийлсэн, Баярт мах бэлтгэж, Цагаадай цаасан мөнгө өгнө” (Мөн тэнд: 229) хэмээн дүрслэн өгүүлснээр нотолж болно.

Зохиолын төгсгөлд нэгэн сонирхолтой зүйл ажиглагдаж буй нь хэдий Занданбал, Хас-Эрдэнэ нар шууд захирах босоо эрх мэдэлтэй хэдий боловч материаллаг хөрөнгийн эзэн түүнээс давуу хүчтэй байгааг Занданбал өвдсөний хойно самуурч байсан сахалтай хятад эр байшингаа султган авахын тулд дамнуурчны есөн гудамжны хогийн цэгт хаяж буйгаар илэрхийлжээ.

Мөн хөдөлмөрийн хөлс, цалингаар дамжуулан хуучин хийгээд шинэ нийгмийн ялгааг харшуулан харуулжээ. Энэхүү санааг анхлан Занданбал Хас-Эрдэнэд тавин төгрөгийг өгч “...Ямар байна. Энэ тавин төгрөгийг Цагаадай чамд өгсөн юм. Өнөө орой Халзан мужаан чамд дээлийн торго авчирч өгнө хэмээсэн. Бас Өндөр чамд гутал авч өгнө гэж байна шүү. Миний өвгөнд эд нар чинь унаж байна шүү” (МӨТД, 2015: 228) гэж зохиолд өгүүлснээр нотолж болно. Уг хэсгээс хөдөлмөрийн өртгийг тооцоолон, арилжих тодорхой үнэ тогтоогүй, тухайн хөдөлмөрийн харилцаанд орж буй хүн өөрийн сэтгэл хөдлөлд тулгуурлан үнийг хөөргөж, унагаах боломжтой хуучин эдийн засгийн харилцааг харж болно. Мөн уг эдийн засгийн харилцаа нь нийгмийн баталгааг үл хангах, тогтворгүй шинжтэй болохыг Занданбал өвчин олсны удаагаар “...хэрхэх аргагүй ганцаардаж, өөрийн торго дурдам дээлийг энэ тэрийн гар амыг харж худалдуулан хэрэглэсээр эд хөрөнгө нь нэгэнт бусдын гараар хааш яаш үрэгдэж, хоёр сарын дотор бараг төлөв хоосрон доройтов” (Мөн тэнд: 231) хэмээх хэсгээр батлах юм.

Туужид тодорхой хэлцлийн дагуу, тогтмол цалин авах хөдөлмөрийн харилцаагаар шинэ нийгмийг илэрхийлсэн байна. Зохиолын төсгөлд Хас-Эрдэнэ машин цохиж сураад, сар тутам 120 төгрөгийн цалинтай бага сургуульд бичээчийн ажилд орсон тухай өгүүлсэн нь тухайн дүр хөдөлмөрийг сэтгэл хөдлөлд тулгуурласан эд бараагаар солилцох хуучин эдийн засгийн харилцаанаас хөдөлмөрийг мөнгөн дүнгээр солилцох шинэ эдийн засгийн харилцаанд шилжиж буйгаар нотолж болно.

Дүгнэлт

М.Ядамсүрэнгийн “Гурван хүүхэн” туужийн хам сэдвийг задлан шинжилж, тайлан тайлбарлахад дараах шинжтэй байна.

1. Уг туужийн утга зохиолын хам сэдвийг шинжлэн үзвэл ардын үлгэрийн “гэрээс гарах” чиг үүргийг эрэгтэй биш эмэгтэй дүрд авчирч, зөвхөн гэрлэлтээр бус, эрдэм сурахаар гэрээс гарч байгаа эмэгтэй дүрийг бүтээснээрээ дэвшилтэт чанартай байна. Мөн туслагч баатар болон хойт эх, дагавар охины мөчлөг үлгэрийн хэв шинжийг ашигласан нь түгээмэл шинжтэй аман зохиолын уламжлалыг хадгалж буйг батлах юм.
2. Зохиолын нийгэм, улс төрийн хам сэдвийг шинжлэн үзэхэд эмэгтэйчүүдийг боловсрол эзэмших, гэр ахуйн хүрээнээс гарч, нийгмийн амьдралд идэвхтэй оролцоход шинэ ба хуучин нийгмийн төлөөлөл хэрхэн хандаж буй байдлаар дамжуулан хуучин нийгмийн тогтолцоог шүүмжлэн харуулжээ. Улс төрийн хам сэдэв нь тухайн нийгэм цаг үеийн үзэл суртал, ухуулга болон зонхилох засаглалын хэлбэрт ач холбогдол өгч байгаа нь зохиолчийн хүүрнэлээр дамжин илэрч байна.
3. Зохиолд хуучин нийгмийн мөхлийг Занданбалын бие дээрх яр шарх, өвчин эмгэг, үхлээр илэрхийлсэн бол бүтээж буй шинэ нийгмээ эрдэм боловсрол эзэмшсэн Хоролмаа бүсгүйн дүрээр, нийгмийн шилжилтийн үеийн алдаа оноог Хас-Эрдэнэ бүсгүйн дүрээр дүрслэн

үзүүлсэн байна. Харин эмэгтэйчүүдийг уруу татаж байсан хятад эрэгтэйчүүдийн дүрээр үндэстэн улс байгуулахад тулгарч болох эрсдэлийг үзүүлж, гадаад колоничлолын сүүдрийг эмэгтэй хүний биеийг ашиглан дүрсэлсэн юм.

4. Үүний зэрэгцээ эцгийн гэрээс гарч, эрдэм сурахаар явж буй Хас-эрдэнийн дүрээр зохиолч эмэгтэйчүүдийг гэр ахуйн хүрээнээс татан, нийгмийн тавцанд гаргахыг зорьсон боловч эцэст нь намын гишүүн нөхөртэй гэрлүүлснээр гэр ахуйн явцуу хүрээнд дахин татан оруулж, эмэгтэй дүрийн бие даасан байдалд эргэлзэж буйгаа зохиолч харуулжээ. Эмэгтэйчүүдийн хам сэдэвт хамаарах эдгээр шинжийг эмэгтэй хүйсийг объект, эрэгтэй хүйсийг субъект болгон дүрсэлсэн хэмээн нэгтгэн үзэж болох юм.
5. Уг туужийн соёлын хам сэдвийг авч үзвэл идээ ундааны соёлоор уламжлалт хийгээд харь соёлын дунд буй бие хүн, өөрийн соёлоос бусдын соёлын хил рүү нэвтэрч буй дүрийн сэтгэл зүйг гаргажээ. Мөн зохиолд хуучин болон шинэ нийгэм, шинэ шинжлэх ухааны эсрэгцлийг анагаах ухаанаар илэрхийлж, хятад, төвөд эмнэлгийг европ эмнэлэг, шинжлэх ухааны ололттой эсрэгцүүлэн үзүүлсэн байна.
6. Эдийн засгийн хам сэдвийг шинжлэн үзвэл босоо болон хэвтээ чиглэлд хамаарах сонирхолтой хөдөлмөрийн харилцаагаар тулгуурлан хүчний шилжилтийг харуулсан байна. Үүний зэрэгцээ хуучин нийгмийн эдийн засгийн харилцааг эмэгтэйчүүдийн биеэ капитал болгож зарах, арилжих, бусдын биеийг албадан үнэлүүлэх, эд бараа солилцох харилцаагаар илэрхийлсэн бол шинэ нийгмийн эдийн засгийн харилцааг шударга хөдөлмөр, тогтвортой ажлын байр, цалин хөлсөөр илэрхийлж, хөдөлмөрийн харилцаанд шилжиж буйгаар харуулж байна.

Ном зүй

Монгол хэлээр

- Баттөмөр, Д. (2005). *Логик, эпистемологи, шинжлэх ухааны философийн асуудлууд*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
- Булаг, Э. (2016). *Монгол дахь үндэсний үзэл ба эрлийзжил*. Улаанбаатар: МУИС Пресс.
- Ван Мандуга. (2015). *Мөрдэндэвийн Ядамсүрэн (XX зууны монгол зохиолчид)*. Улаанбаатар: Соёмбо.
- Жэймс Кантон (ред.). (2016). *Утга зохиол*. Улаанбаатар: Монсудар.
- Лувсанвандан, С., Түдэв, Л., Цэдэв, Д., нар. (1985). *Монголын уран зохиолын түүх I (1921-1940)*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар
- Лэви Стросс. (2013). *Бүтцийн антропологи*. орч. Ж.Отгонбаяр. Улаанбаатар: Монсудар.
- Майкл Райан. (2018). *Задлан шинжлэх тухай: Уран зохиол, кино, соёл урлаг*. Улаанбаатар: Жиком пресс.
- Нандинбилиг, Г. (2018). *Эх зохиол задлан шинжилж, үнэлэх арга зүй*. Улаанбаатар: МУИС Пресс хэвлэлийн газар.
- Нандинбилиг, Г., Дулам, С. (2020). *Монгол аман зохиолын онол II (Хүүрнэн өгүүлэх аман зохиол, Жүжиг наадмын аман зохиол)*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
- Нандинбилиг, Г. Монгол идээ ундааны бэлгэдэл: Тавгийн идээ. *Nomadic Studies*, 22 (29), 168-181.
- Нямсүрэн, Ц. (2017). *Монгол, грек туульсын бүтцийг харьцуулан судалсан нь*. Улаанбаатар: Үсэг хоршоо.
- Отгонбаяр, М., Онон, Ц., Энхбаяр, Б., Баасандорж, Э., Мөнхжавхлан, Б., Дагзмаа, Б., Бүжинлхам, С., Гомбосүрэн, Ц., Нямсүрэн, Ц. (2023). *Нийгэм-улс төрийн философийн орчин үеийн онолууд*. Улаанбаатар: Тото пресс.

Ядамсүрэн, М. (2015). Гурван хүүхэн. In Дашням, Л., Батбаяр, Д. (Эмх.). *Монголын өгүүллэг туужийн дээж*. (218-234 тх.). Улаанбаатар: Монсудар.

1924 оны Монгол Улсын Үндсэн хууль. Legal Info: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1924.html>

Гадаад хэлээр

Mulvey, Laura. (1999). Visual Pleasure and Narrative Cinema. In Leo Braudy and Marshall Cohen. (Eds.). *Film Theory and Criticism: Introductory Reading*. (pp. 833-844). New York: Oxford University Press.

Propp, Vladimir. (2009). *Morphology of the Folktale*, trans. Laurence Scott. Austin: University of Texas Press.

Spivak, Gayatri Chakravorty. (1992). Woman in Difference: Mahasweta Devi's 'Douloti the Bountiful'. In Andrew Parker, Mary Russo, Doris Sommer, and Patricia Yaeger. (Eds.). *Nationalisms and Sexuality*. (pp. 96-120). New York: Routledge.

QCAA. (2017). *Approaches to Reading Practices* [A Resource for English and Literature Extension]. https://www.qcaa.qld.edu.au/downloads/senior/snr_eng_extn_20_res_read_prac.pdf.

Abstract

In this paper, we analyze the context of the novella “Gurvan khüükhen (Three Girls)” by Yadamsüren Mördendev, known as the Mongolian literary figure of the modern era, and interpret the implications of this. To gain a deep comprehension of any text, it's crucial to thoroughly examine its contexts, including history, social phenomena, stratification, political ideology, religious beliefs, and cultural symbols. We analyzed and interpreted the literary, social, political, cultural, economic, women's, and author's contexts and their role in the novella.

The plot of the novella “Gurvan khüükhen”, first published in 1936, begins with the action of the female character “leaving the home” and shows the situation of Mongols at the beginning of the revolution, the old and new social ideology. In doing this, the female body is objectified, symbolizing the inevitable decline of the old society through the portrayal of Zandanbal. She becomes immersed in the old city's life, trapped in its wounds, and ultimately perishes. Conversely, the advancements of the new society are embodied by the teacher Khorolmaa, while the societal transition's missteps are exemplified by Khas-Erdene. The portrayal of how representatives from both the old and new societies influence women's independent decision-making and education is shaped by various social, cultural, political, and economic contexts.

Keywords: Fiction, context, absentation function, society, culture, politic, women, power